



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/543

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7¹.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар албан даалгавар /Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах/-ыг хэрэгжүүлэх, ковид-19-ын халдвар тархалтын үед иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Оюу мандлын орон сууцны барилгын дулааны шугам сүлжээний засварт 18,0 сая, "Гранд пасикал" ХХК-ийн 30 айлын орон сууцны гадна УДДТ-7-д цэвэр усны өргөлтийн насос суурилуулахад /2ш/ 1,21 сая, 1, 2 дугаар 24 айлын чиглэлийн 2 дугаар хэлхээний шугам шинэчлэхэд 39,89 сая төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнүүдэд зарцуулах 59 100 000 төгрөг /тавин есөн сая нэг зуун мянга/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.3-д тусгагдсан "1 дүгээр сургуулийн багш нарын байрны буулгалтын зардал, байр авах" зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ